

## НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН ЧАНАРЫН БОДЛОГО

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү бодлогын баримт бичиг нь Дээд боловсролын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2014-2024 онд төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, НССДС-ийн хөгжлийн төлөвлөлт /мастер төлөвлөгөө 2016-2022/, Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 зэрэг баримт бичигт үндэслэнэ.
2. НССДС-ийн чанарын бодлого нь сургуулийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, тэдгээрийн биелэлт, шалгуур үзүүлэлт, үр дүн, чанарыг хэмжих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, баталгаажуулах, төлөв байдлыг тогтоох, сургалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, сургуулийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох, олон улсын жишигт хүргэхэд чиглэнэ.
3. Чанарын бодлогын хамрах хүрээ нь НССДС болон түүний үйл ажиллагаанд оролцогч, сонирхогч талуудад хамраана.

### Хоёр. Чанарын бодлогын тодорхойлолт

1. **Зорилго:** “Үндэсний болон олон улсын стандартад нийцсэн, үр дүнд суурилсан сургалтын үйлчилгээ үзүүлдэг, чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлсэн, үр бүтээлтэй ажил хөдөлмөр эрхлэж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, үр чадвар, ёс суртахуунтай, тасралтгүй суралцан хөгжих дадал чадвар эзэмшсэн үлгэр жишээ мэргэжилтэн бэлтгэдэг их сургууль болно”
2. **Зорилт:**
  - 1) Чанарын удирдлагын тогтолцоо /ISO9001:2015/, Боловсролын байгууллагын менежментийн стандартыг /ISO21001:2018/ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж, тус стандартуудыг үйл ажиллагаандаа албан ёсоор нэвтрүүлэн хэрэгжүүлэх, сайжруулах.
  - 2) Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шаардлага, шалгуур үзүүлэлтийг ханган биелүүлэх ажлыг зохион байгуулж, амжилттай магадлан итгэмжлүүлэх.
  - 3) Чанарын дотоод баталгаажуулалтыг хариуцан гүйцэтгэх Хөтөлбөр, чанарын баталгаажилтын албыг шинээр байгуулж сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааг үнэлэх, тасралтгүй сайжруулах, чанарыг баталгаажуулалтыг тогтвортой хөгжүүлэх.
3. **Баримтлах зарчим:**
  - 1) Эрх зүйн болон ёс зүйн хэм хэмжээг баримтлан сахих;
  - 2) Үйл ажиллагаа тодорхой, ойлгомжтой, дэс дараалалтай, харилцан уялдаатай, төлөвлөлттэй байх арга хандлагыг тогтоон бэхжүүлэх;
  - 3) Чанарын удирдлагын тогтолцоонд багш, ажилтны оролцоог бүрэн хангаж, тэдний чадвар чадамжийг хөгжүүлэх;
  - 4) Чанар, гүйцэтгэлийн шинжилгээ, үнэлгээ, баталгаажуулалт нь нотолгоонд суурилсан, хараат бус, шударга, мэдээллийн нууцлалыг хангасан, үнэн зөв, тогтвортой байх;
  - 5) Сургалтын бодлого, үйл ажиллагаа чанартай, тогтвортой, хүртээмжтэй, нээлттэй, тэгш боломж олгосон, олон хувилбартай, техник, технологийн дэвшилд суурилсан, залгамж холбоотой байх;

- 6) Хамт олны харилцаа, хандлага, хувь хүний хөгжил, ёс зүйг чанарын соёлын үндсэн хэсэг хэмээн үзэж, чанарын төлөө хамтран ажиллах;
- 7) Суралцагчийн заавал эзэмших мэдлэг, үр чадвар, дадлыг бүрэн хангаж төгсөгч, ажил олгогч, нийгмийн эрэлт хэрэгцээ, хүлээлтэнд төвлөрдөг байх;
- 8) Судалгаа, мэдээлэл, өгөгдөлийн дүн шинжилгээнд үндэслэсэн, эрх зүйд нийцсэн шийдвэр гаргах;
- 9) Багш, ажилтан, суралцагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг өргөтгөх;
- 10) Нийгмийн өмнө хариуцлагатай байж, хамтын ажиллагааг дэмжих, бэхжүүлэх.

#### **Гурав. Үүрэг, хариуцлага**

1. Захирал /захирлын зөвлөл/:
  - 1) Чанарын бодлого, зорилтын хэрэгжилтийн үр дүн, төлөвлөгөөний тайланд хичээлийн жил бүр шинжилгээ хийж дүгнэх, зөвлөмж гаргах.
  - 2) Чанарын бодлого, зорилт, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн тогтвортой дэмжлэг үзүүлэх.
2. Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба:
  - 1) Чиг үүргийн хүрээнд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх, тайлагнах.
  - 2) Чанарын бодлого, зорилтын нийцэл, тохиромжтой байдалд дүн шинжилгээ хийх.
  - 3) Сургалтын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах арга зам, аргачлалыг тодорхойлох, шаардлагатай судалгааг хийх, санал асуулга явуулах, харьцуулах, хяналт-үнэлгээ, дүн шинжилгээ хийх, нийцэл, ахиц дэвшлийг баталгаажуулах, үл тохирлыг илрүүлэх, санал боловсруулах, зохих заавар, зөвлөмж гаргах.
  - 4) Сургуулийн хэмжээнд чанарын бодлого, зорилтыг мэдээллэх, ойлгуулах, хүртээмжтэй байлгах, мэргэжлийн удирдлагаар хангах.
3. Бусад нэгж, багш, ажилтан:
  - 1) Сургуулийн чанарын бодлого, зорилтыг ойлгон дэмжиж, хэрэгжүүлж ажиллах.
  - 2) Алба, нэгжүүд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө холбогдох чиглэлийн дагуу чанарын бодлого, зорилтоо нарийвчлан тусгаж хэрэгжүүлэх.

*(2022 онд нэмэлт оруулсан)*

----- оОо-----

НССДС-ийн “ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО”



НССДС нь багш, ажилтан, оюутан суралцагч, оролцогч талуудын аюулгүй байдлыг эрхэмлэж, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ. Үүний тулд холбогдох хууль тогтоомж, стандартыг хангасан хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгон хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулан ажиллана.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын тулд дараах бодлогыг хэрэгжүүлнэ:

1. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулалт, үндэсний стандартуудын шаардлага, нийцлийг ханган ажиллана.
2. Сургуулийн хэмжээнд эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
3. Нийт хамт олон, гэрээт багш, ажилтнууд хэрэгцээнд нийцсэн ХЭМАБ-ын мэдлэг, үр чадвар олгох сургалтыг хуулийн дагуу шат дараалалтайгаар тогтмол зохион байгуулна.
4. Багш, ажилтан, оюутан суралцагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй аюулыг бүх төвшинд илрүүлж, эрсдэлийг бүүруулах, арилгах замаар ХЭМАБ-ыг ханган тасралтгүй сайжруулна.
5. Захирал, менежерүүд ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоог бий болгоход манлайлан байгууллагын ХЭМАБ-ын соёлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
6. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын үр нөлөөтэй тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулахад нийт ажилтан болон бусад оролцогч талуудын санал, санаачлага ба үүрэг, оролцоог дэмжинэ.
7. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийг тухайн хичээлийн жилийн төсөвт тусгаж шийдвэрлэж байна.

## НССДС-ийн “МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО”



НССДС нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах энэхүү бодлогын зорилго нь албан харилцаа болон багш, ажилтан оюутны мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдал, сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдалд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоог бий болгох арга замаар мэдээллийн аюулгүй байдлыг ханган удирдахад оршино.

Сургуулийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд дараах бодлогыг баримтална:

1. Багш, ажилтан, оюутан, оролцогч талууд, олон нийтэд ил байх шаардлагатай мэдээллээс бусад мэдээллийг нууцлалтай гэж үзнэ. Үүнд мэдээллийн бүх төрлийн тээгч, зөөгч, агуулагч, сургуулийн удирдлага мэдээллийн болон суралцагчийн мэдээллийн систем, сургуулийн вэбсайт зэргийг адилтган үзэж хяналтад байлгана.
2. Хэрэглэгчийн хувийн мэдээллийг болон байгууллагын өөрийн мэдээллийг аюулгүй байлгаж, хадгалж хамгаалахын зэрэгцээ хүртээмжтэй байдал, үнэн зөв байдлыг хангахад тэгш хандаж ажиллана.
3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийг тухайн хичээлийн жилийн төсөвт тусгаж шийдвэрлэж байна.
4. Мэдээллийн системд хандах эрх бүхий хэрэглэгчид /багш, ажилтан, албан тушаалтан, оюутанд/ шаардлагатай мэдээллээ олох боломжтой байлгаж, түүний ашиглалтыг хянаж болохуйц байлгана.
5. Мэдээллийн аюулгүй байдалд хамаарах, сонирхогч талуудын шаардлага болон хууль, зохицуулалтын шаардлагуудад байнга нийцлийг хангаж ажиллана.
6. Мэдээллийн аюулгүй байдлын нарийвчилсан шаардлагуудыг тогтоон мөрдөж ажиллана.

## НССДС-ИЙН “АВИЛГЫН ЭСРЭГ БОДЛОГО”




НССДС-ийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамт олон, оюутан суралцагсдад шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, шударга, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулахад энэхүү бодлогын зорилго оршино.

Сургуулийн хэмжээнд авлигын эсрэг тэмцэхэд дараах бодлогыг баримтална:

1. Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах ажлыг ил тод, нээлттэй зохион байгуулах, удирдлага, багш, ажилтны хариуцлагыг дээшлүүлэх.
2. Хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлэх, сургуулийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх.
3. Албан тушаалтан бүр албан үүргээ гүйцэтгэхдээ оюутан, хэрэглэгчдийн ашиг сонирхлыг илүүд үзэн, албан тушаалаа ашиг олох хэрэгсэл болгохгүй байх.
4. Жил бүрийн 12-р сарын 09-нд болдог “Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийг сургуулийн хэмжээнд тэмдэглэдэн өнгөрүүлдэг байх.
5. Багш, ажилтанд авлигаас ангид байх чиглэлээр жил бүр сургалт зохион байгуулах.
6. Авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор авлигын эсрэг боловсрол олгох чиглэлээр сургалтын хөтөлбөрт тусгах.
7. Сургуулийн вэбсайт, дотоод мэдээллийн системээр дамжуулан сургалтанд оролцогч талууд, олон нийтэд авлигаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл тогтмол түгээх.

НССДС-ИЙН “ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГО”



Эрэгтэй, эмэгтэй хүн үлс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг жендэрийн эрх тэгш байдал гэдэг билээ.

НССДС-ийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ялангуяа боловсрол эзэмших тэгш эрх, тэгш боломжийг хангах, хамт олон, оюутан суралцагсад аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд энэхүү бодлогын зорилго оршино.

Сургуулийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад дараах бодлогыг баримтална:

- Жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлж суралцах, боловсрол эзэмшихэд аливаа хүнийг арьс өнгө, хэл соёл, угсаа гарвал, нас, хүйс, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, үзэл бодлоор нь ялгаварлан харьцахыг үл тэвчинэ.
- Оюутан, суралцагсадыг элсүүлэхдээ хүйсээс хамааран ялгаатай шаардлага, нөхцөл тогтоохгүй, элсүүлэхээс татгалзахгүй байж, сургалтын ба бусад үйлчилгээ /сургалтын тэтгэлэг авах гм/ үзүүлэхдээ тэгш эрх, тэгш боломжийг хангана.
- Боловсролын харилцаанд хүйс, бэлгийн чиг баримжаанаас үл хамааран тэгш эрхтэй оролцох, суралцах адил боломж, нөхцөлийг хангана.
- Зайлшгүй шаардлагатай тохиолдолд зөвхөн нэг хүйсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн болон бусад /оюутны дотуур байр/ үйлчилгээг зохион байгуулна.
- Сургуулийн ажлын байр, сургалтын орчныг аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байлгаж, жендэрийн тухай сургалт явуулдаг байна.
- Бакалаврын сургалтын зохих хичээлийн хөтөлбөрт жэндер, ялгаварлан гадуурхалтын тухай сэдэв, агуулга оруулна.
- Гей, лесбиян болон бисексуал хэлбэрийн бэлгийн харилцаанд бусдыг уруу татан оруулах зорилготой үг, үйлдлийг үл дэмжинэ.
- Хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгаж, жендэрийн мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангана.
- Сургуулийн ажлын тайланд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн, гарсан зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээг заавал тусгаж байна.

## НССДС-ийн “ТАМХИНЫ ЭСРЭГ БОДЛОГО”




НССДС-ийн Тамхины эсрэг бодлого нь сургуулийн орчинг “тамхигүй орчин” байлгах, Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, багш, ажилтан, оюутан, иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад тодорхой хувь нэмэр оруулахад оршино.

Жил бүр дэлхий даяар зөвхөн тамхидалтаас болж 7 сая гаруй хүн хорвоог орхиж байна. Иймд иргэдийн тамхидалтыг багасгах, тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх, дам тамхидалтаас урьдчилан сэргийлэх, тамхинаас үүдэлтэй эрүүл мэндийн эрсдэл, нас баралтыг бууруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах нь чухал юм.

Сургуулийн хэмжээнд тамхигүй орчныг бүрдүүлэхэд дараах бодлогыг баримтална:

1. Тамхины хяналтын үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих.
2. Жил бүрийн 5-р сарын 31-нд болдог “Дэлхийн тамхигүй өдөр”-ийг сургуулийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлдэг байх.
3. Хамт олон, оюутнуудад тамхидалтын аюул, эрсдэлийн талаар жил бүр сургалт зохион байгуулах.
4. Хүний эрүүл мэнд, гоо сайхан, эдийн засагт тамхины учруулах хор хөнөөлийн талаар мэдээлэл, зурагт ухуулга зэргийг сургуулийн орчинд байршуулах зэргээр нөлөөллийн үйл ажилллагаа явуулах.
5. Тамхинаас гарсан багш, ажилтан, оюутанг сурталчилах, урамшуулах.

## НССДС-ийн “НОМ, СУРАХ БИЧГИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”



НССДС-ийн ном, сурах бичгийн талаар баримтлах бодлого нь оюутан суралцагч, багш, ажилтныг шаардлагатай мэргэжлийн чиглэлийн ном, сурах бичгээр хангах, ном, сурах бичгийн олон янзын төрөл хэлбэрийг чөлөөтэй ашиглах боломж, нөхцөлийг бүрдүүлэх номын сангийн фондыг нэмэгдүүлэх, Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний мэдлэг, оюуны хөгжилд тодорхой хувь нэмэр оруулахад оршино.

Сургуулийн хэмжээнд ном, сурах бичгийн талаар дараах бодлогыг баримтална:

1. Шинэ номын мэдээллийг номын сангийн систем болон сургуулийн вэбсайтаар дамжуулан хэрэглэгчдэд шүүрхай хүргэдэг байх.
2. Оюутан суралцагч, багш, ажилтнууд харилцан номын мэдээлэл солилцох, хувийн номнуудаа сольж уншдаг байх ажлыг тогтмол зохион байгуулах.
3. Тухайн хичээлийн жилд худалдан авах ном, сурах бичиг, цахим материалын төсвийг баталж, хэрэгжилтийг хянадаг байх.
4. Хичээлийн улирал бүрийн эхний 20 хоногт багтаан шаардлагатай ном, сурах бичгийн судалгааг хийж, худалдан авах ном, сурах бичгийн нэр төрөл, тоо бүхий жагсаалтыг гаргаж, төсөвт багтаан стандарт шаардлага хангасан ном, сурах бичгийг өрсөлдүүлэх зарчмаар худалдан авдаг байх.
5. Зохиогчийн эрх эзэмшигчтэй гэрээ байгуулсны үндсэн дээр өөрийн сан хөмрөгт байгаа ном хэвлэлийг бүрэн болон хэсэгчлэн цахим хэлбэрт оруулж цахим уншлагын үйлчилгээг өргөжүүлэх.
6. Ном, сурах бичгийг судлах, худалдан авахтай холбоотой зааврыг баталж мөрдүүлдэг байх.
7. Номын санг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлдэг, ном, материал хандивладаг, гадаад, дотоодын байгууллага, сан, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах.
8. Номын сангаар идэвхтэй үйлчлүүлэгчдийг дэмжих, урамшуулах ажил зохион байгуулдаг байх.





## НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

/2022-2026 он/

### ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулж, Сэтгэл судлал, Сургуулийн өмнөх боловсролын багш, Бага ангийн боловсролын багш, Нийгмийн ажил, Солонгос хэлний орчуулга мэргэжлүүдээр Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр хэрэгжүүлж байна.
- Бид профессор багш нарыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, сургалт, судалгааны чанар, үр дүн болон төгсөгчдийн мэдлэг, үр чадварыг олон улсын түвшинд хүргэх, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангах, дээд боловсролын хөгжил, шинэчлэлийн талаар төрөөс баримтлаж буй бодлого, үйл ажиллагааг дэмжиж Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд нийцүүлэн сургуулийнхаа “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг /цаашид “хөтөлбөр” гэнэ/ боловсруулан хэрэгжүүлэх нь нэн чухал хэмээн үзэж байна.
- **Багш хөгжихийн учир:** Монгол улс төдийгүй дэлхий дахинд нийгмийн гүн гүнзгий өөрчлөлт гарч нийгэм, эдийн засагт өнөөдөр төдийгүй маргааш хэрэгтэй үр чадвар, чадамжийг дэмждэг боловсролын шинэ хандлага, хэлбэрийг шаардаж байна. Энэ нь боловсролын бүхий л түвшинд ерөнхий суурь эрдмээс гадна шударга ёс, нийгмийн тэгш байдал, эв нэгдлийн үзэл санаанд сургах бодлого үйлчилж, сурах орчин, суралцах шинэ хандлагыг бий болгох тухай цогц ойлголт юм. Хурдтай өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд чанартай суурь боловсролоос эхлээд чанартай дээд боловсрол, насан туршийн чанартай боловсрол хамгийн чухал баялагт тооцогдох боллоо.
- **Багш хөгжихийн учир:** 21-р зууны боловсролын үндсэн зорилго бол хүний нэр төр, авьяас чадвар, амьдралын сайн сайхан бүхнийг байгаль орчинтой уялдаатайгаар хадгалан бэхжүүлэхэд оршино. Дэлхийн хөгжил өнөөдөр нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн бие биенээсээ хамаарал бүхий, бие биенээ нөхөх 3 талт тогтвортой хөгжлийн бодлогод суурилж байгаа бөгөөд энэхүү бодлогын цөм нь боловсролыг бүх нийтийн баялаг гэж үзэхэд оршино. Чанартай дээд боловсрол, сургалтууд нь дэлхийн болон үндэсний хэмжээнд гарч буй байгаль орчин, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүдэд дасан зохицох чадавхийг хувь хүн, нийгмийн бүлгүүдэд олгоход шийдвэрлэх үүрэгтэй. Боловсрол хүний сайн сайхан байдлыг хангахын төлөөх альтернатив арга замуудыг хайхдаа хүмүүнлэг хандлагыг удирдлага болгохыг илүү чухалчилж байна.<sup>1</sup>

<sup>1</sup> “Үр бүтээлтэй, байнга суралцдаг, асуудлыг шийдвэрлэдэг, хамтдаа болон байгальтай энх тайвнаар болон харилцан зохицон амьдрах чадвар бүхий өнөө үед зайлшгүй шаардлагатай байгаа хүний нөөцийг бий болгодог боловсролын систем нь эрх мэдэл, өөртөө итгэх итгэл олгодог байна. Улс орнууд ийм боловсролыг бүх нийтэд амьдралынх нь туршид хүртээмжтэй болгосноор боловсрол тогтвортой хөгжлийн хөдөлгөгч хүч, илүү сайхан нийгэм бий болгох гол түлхүүр болох бөгөөд нэг ёсны чимээгүй хувьсгал гарна”. “Боловсролын хүч чадал: Бүх нийтийн боловсрол, хөгжил, даяаршил”, ЮНЕСКО. Лондон., 2015

- **Багш хөгжихийн учир:** Хүртээмжтэй боловсрол, нэг ч хүнийг нийгмээс тусгаарлаж орхигдуулахгүй, нийгмээс хаягдсан байдалд оруулахгүй байхад хүмүүнлэг хандлага гол анхаарлаа хандуулдаг. Ийм хандлага нь дэлхийн хэмжээнд боловсролын салбарыг өөрчлөх үйл явцад баримтлах гол зарчим болдог бөгөөд энэхүү өөрчлөлтийн хүрээнд бүх нийтийн тогтвортой хөгжлийн тусын тулд суралцах үйл ажиллагааг явуулахад багш, сурган хүмүүжүүлэгчдэд урьдын адил чухал үүрэг ногдож байна.
- **Хөтөлбөрийн зорилго:** Сургуулийн стратеги төлөвлөгөө, Чанарын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, багшийг сургалт, судалгаа, хувь хүний мэдлэг, чадамжийг тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, багшлах бүрэлдэхүүнийг чанаржуулах нөхцөл, боломжийг хангахад оршино.
- **Хөтөлбөрийн зорилт:**
  - Зорилт 1. Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, сургах, сурах сургалтын үйл явцыг шинэ түвшинд хүргэх.
  - Зорилт 2. Багшийн судалгааны ажлын түвшинг сайжруулах, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр чадавхжуулан эрдэмжүүлэх.
  - Зорилт 3. Багшийн эрдэм мэдлэгээ түгээн дэлгэрүүлэх, нийгмийн хүлээлт шаардлагад нийцүүлэн өөрийгөө хөгжүүлэх, чадамжийг дэмжих.
  - Зорилт 4. Багшийн ажлын үр дүн, хөдөлмөрийн үнэлгээ, цалин урамшууллын тогтолцоог бэхжүүлэх, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн хамгааллыг сайжруулах.
- **Хөтөлбөрийн хугацаа:** Хөтөлбөрийг 2022-2026 онд хэрэгжүүлнэ.
- Хөтөлбөрийг тасралтгүй, тогтвортойгоор багш, тэнхим, нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн үйл ажиллагаа нээлттэй, тэгш, хүртээмжтэй, академик эрх чөлөөг хангасан, сургуулийн хэрэгцээ шаардлага, багшийн хөгжлийн түвшин, боломж, хэрэгцээ сонирхол, байгууллагын санхүүгийн нөөц боломжид тулгуурласан байна.
- **"Багшийн хөгжил"** гэж багшийн мэдлэг, арга зүй, үр чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг, **"Багшийн хөгжлийн төв"** гэж багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихөд шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүхий орчинг, **"чадамж"** гэж тодорхой ажил, даалгаврыг үр дүнтэй биелүүлэх чадвар, мэдлэгийг тус тус ойлгоно.

### НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 1.1. Багшийг хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлсэн байна.
- 1.2. Багшийг хөгжүүлэх төсвийг батлан зарцуулж хэвшсэн, нөөцийг бүрдүүлсэн, төсвийг тогтвортой нэмэгдүүлэх нөхцлийг хангасан байна.
- 1.3. Дотооддоо зохион байгуулсан сургалтын тоо, хэмжээ, төрөл, сургалтанд хамрагдсан багшийн тоо нэмэгдсэн байна.
- 1.4. Шаардлагатай сургалтанд багшийг бодлогоор оролцуулсан, инновацид суурилсан сургалтын арга, технологи эзэмшүүлсэн, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн тоо, хэмжээ нэмэгдсэн байна.
- 1.5. Багшийн гадаад хэл, мэдээллийн технологийн мэдлэг, үр чадвар нэмэгдсэн байна.
- 1.6. Сургалтын чанар, төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна.
- 1.7. Багшийн судалгааны ажлын тоо, хэмжээ, дотоод, гадаадын сэтгүүлд хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, тайлан, материалын тоо нэмэгдсэн байна.
- 1.8. Багш нарын оролцсон олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, судалгааны төсөл, инновацийн төсөл, гэрээт ажлын тоо нэмэгдсэн байна.

- 1.9. Бизнесийн болон бусад байгууллагад ажилласан, дадлага хийсэн багшийн тоо нэмэгдсэн байна.
- 1.10. Сургуулиас санхүүжүүлсэн эрдэм шинжилгээний ажил, төсөл, гэрээт ажлын тоо нэмэгдсэн, судалгааны ажлынхаа үр дүнгээр багшийн түүрвисан бүтээл /ном, сурах бичиг, гарын авлага, патент г.м/-ийг хэвлэх, хэрэглээнд оруулахад дэмжлэг үзүүлдэг байна.
- 1.11. Багш нарын эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны ажил, багш нарын магистр, докторын ажил, бусад бүтээлийг цахим хуудас, мэдээллийн санд оруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.
- 1.12. Докторантурт элссэн, докторын зэрэг хамгаалсан багшийн тоо нэмэгдсэн, дэд профессор, профессорын албан тушаалд ажиллах боломж бүрдсэн байна.
- 1.13. Сургуулийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах санаачлага гаргаж хэрэгжүүлсэн, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь оруулсан /улсын хэмжээний төсөл дээр ажилласан, заавар, зөвлөмж боловсруулсан, мэргэжлийн байгууллагуудыг удирдаж амжилтанд хүрсэн гэх мэт/, сургуулийн нэр хүндийг өндөрт өргөсөн багшийг алдаршуулан урамшуулдаг байна.
- 1.14. Олон жил үр бүтээлтэй ажилласан багшид байгууллагын тэтгэлэг, тэтгэмж, урамшуулал олгох нөхцлийг хангасан байна.
- 1.15. Багшийн хөгжлийг дэмжих, ажлын үр дүнг бодитой дүгнэх, үнэлэх, урамшуулах механизм бүрдүүлсэн байна.
- 1.16. Багш нарын ажлын байрны нөхцөл сайжирсан, цалин хөлсийг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлдэг байна.
- 1.17. Багшийг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулдаг, эмнэлэг, сувиллын газартай хамтран ажиллах гэрээ байгуулан багш, ажилтны эрүүл мэндийг хамгаалдаг байна.

## ХОЁР. БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮНЭЛГЭЭ

- 2.1. хүргэхээр энэхүү хөтөлбөрт тусгаж байна.
  - 2.1.1. Багш бүр мэдлэг, оюуны өндөр чадамжтай байх:
    - Дэлхийн болон үндэсний, салбарынхаа хөгжлийн чиг хандлагыг бүрэн мэдэрч, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, системтэй бодох, үнэлэх, дүгнэх, асуудлыг зөв зохистой шийдвэрлэх, багаар ажиллах, нээлттэй эх сурвалжуудаас мэдээллийг чөлөөтэй хайх, ашиглах зэрэг олон талт чадваруудыг дээд зэргээр эзэмшсэн байх.
    - Судлаачийн хувьд шинжлэх ухаанч, байнга шинийг эрэлхийлэгч, бусдын үзэл бодлыг хүндлэгч, олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрөгч, эрдэмтэн судлаач байхын төлөө үргэлж тэмүүлэгч байх.
  - 2.1.2 Багш бүр сургахуйн чадамж өндөртэй, хувийн сахилга баттай байх:
    - Сургалт, заах арга зүйн чиглэлээр салбартаа сайн бодлого боловсруулагч, сургагч байх, байгаль орчин, нийгмийн сайн сайхны төлөө өөрийнхөө мэдлэг, чадвар, сэтгэлийг зориулах чадвартай байх.
    - Хамт олны дунд нэр хүндтэй, багийн амжилтанд бүтээлчээр дэм болж ажиллах, зөвлөн туслах, удирдан чиглүүлэх, сургах, эрх тэгш байдлыг хүндлэн, бусдын нэр алдрыг дээдлэх, манлайлагчийн үр чадварыг эзэмшсэн байх.
    - Баг, хамт олноо манлайлах, зохион байгуулах, хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээний мэдээллийн харилцаанд соёлтой оролцож, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэгч, хэвлэн нийтлэгч, бусдад зөвлөн туслагч байх үр чадвартай байх.

- Суралцагчаа хүндэтгэдэг, ялгаварлалгүй ханддаг, тэднийг сонсдог, зөвлөдөг, чиглүүлдэг, хамтран ажилладаг, хамтран бүтээдэг чадварыг эзэмшсэн байх.

#### 2.1.3. Багш бүр шинжлэх ухаан, мэдлэгт түшиглэсэн судалгааны чадамжтай байх:

- Судалгааны ажлын төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх, үр дүнг инноваци болгох, түгээх, борлуулах маркетингийн мэдлэг, үр чадвар эзэмших, судалгааны эрсдэлийг төлөвлөх, судалгааны баг удирдах.
- Нийгмийн ач холбогдол бүхий асуудлаар өөрийн гэсэн судалгааны чиглэлтэй байх, мэргэших, хэрэгцээнд тулгуурласан, нийгмийн сайн сайхны төлөө бодлого гаргагчдад нөлөөлөх эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөр боловсруулах, зөвлөх.
- Судлаачийн ёс зүй, хууль эрх зүйн баримт бичгийг сайтар судалж мэдсэн, судалгааны үр дүнд санхүүгийн тогтвортой орлогыг бүрдүүлэх, санхүүгийн менежментийн болон дэд бүтэц, нөөцийн талаар мэдлэг, үр чадвар эзэмшсэн байх.

#### 2.1.4. Багш бүр хувь хүний чадамж өндөртэй байх:

- Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг байнга баяжуулдаг, сургалтын арга зүй, багшлахуйн арга барилдаа үнэлэлт дүгнэлт хийж, үр дүнгээ тасралтгүй хэмждэг, сайжруулдаг, цагийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлдэг, нээлттэй эх сурвалжийг чөлөөтэй ашиглаж чаддаг, аливаа өөрчлөлт, эрсдлийг даван түүлж, дасан зохицох арга замыг хялбархан олдог, түүнийгээ хэрэгжүүлэгч, бусдын үзэл бодлыг хүндэтгэдэг байх.
- Багш мэргэжлийнхээ үнэ цэнийг мэдэрч, хичээлээ үр өгөөжтэй заадаг, ажилдаа дур сонирхолтой, тасралтгүй хөгжих хүсэл тэмүүлэлтэй, өөртөө итгэлтэй, аливаа асуудалд хариуцлагатай ханддаг байх.
- Өөрийн мэдлэг, чадвар нь дэлхийн боловсролын болон хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, шаардлагад нийцэж буй эсэхэд бодит дүгнэлт хийдэг, ажлын байрандаа тасралтгүй хөгжиж, мэдлэгээ бусадтай хуваалцдаг, хамт олны дунд эерэг үүр амьсгал бий болгох чадвартай, зөв харилцаа, хандлагатай байх.

#### 2.2. Хөтөлбөрөөр эзэмших багшийн чадамж, хөгжлийн түвшингийн үзүүлэлт, хамаарал:

Чадамж, үр чадвар	Манлайлал	Сэтгэл судлал	Сургалтын заах арга зүй	Сургалтын бичиг баримт боловсруулалт	Хич/хөтөлбөр, агуулгын чанар, баяжилт	Харилцааны ёс зүй	Судалгааны арга зүй, судлаачийн ёс зүй	Нийтлэл, өгүүлэл, илтгэл бичих арга зүй	Төсөл хөтөлбөр боловсруулах	Гадаад хэл	Мэдээллийн технологи	Инноваци, технологи
Багаар ажиллах	*	*				*						*
Зааж сургах	*	*	*	*	*	*				*	*	
Зөвлөн сургах	*	*	*	*		*						
Нөлөөлөх	*	*	*			*						
Эрх тэгш байдлыг эрхэмлэх		*	*			*						
Сургалтын бичиг баримт боловсруулах, хэрэгжүүлэх	*		*	*						*	*	
Нийгмийн оролцоо, идэвх	*	*	*	*	*	*				*	*	*

Шинжлэх ухааныг суурь мэдлэгийн хэрэглээ болгох						*	*	*	*	*	*
Судалгааны арга зүйг хэрэглээ болгох						*	*	*	*	*	*
Мэдээлэл боловсруулах, тоон шинжилгээ хийх				*		*	*	*		*	*
Гадаад хэлээр харилцах	*				*		*	*	*		*
Системтэй бодох	*	*		*	*		*	*	*		*
Үнэлэлт, дүгнэлт өгөх	*		*	*	*		*	*	*	*	*
Асуудал шийдвэрлэх	*	*	*	*	*	*		*			*
Шинийг илэрхийлэх, инноваци бий болгох	*						*	*	*	*	*
Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах			*				*				*
Судлаачийн ёс зүйг эрхэмлэх							*	*	*		*
Оюуны өмчийг эзэмших ашиглах							*	*	*		*
Судалгааны стратеги төлөвлөлт хийх				*				*			*
Гарааны компани байгуулах, санхүүжилт бүрдүүлэх	*			*		*		*			*
Харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх		*			*				*	*	*
Хэвлэл мэдээллийг ашиглах	*						*	*	*		
Хэвлэн нийтлэх				*			*	*		*	
Тэмүүлэлтэй байх	*	*	*	*		*					*
Манлайлагч байх	*	*	*	*	*	*	*	*	*	*	*
Өөрийгөө илэрхийлэх	*	*	*	*	*	*		*	*	*	*
Хариуцлагатай байх	*	*	*	*	*	*		*	*	*	*
Харилцааны соёлтой байх	*	*	*	*		*		*	*	*	*
Өөрчлөлтөд дасан зохицох	*	*	*		*						*
Ёс суртахуунтай байх	*	*				*		*		*	*

2.3. Багшийн хөгжлийн төлөвлөгөөг /хавсралт-1/ боловсруулахдаа дараах зарчим, чиглэлийг удирдлага болгоно. Үүнд:

- 2.3.1. Хөтөлбөрийн зорилт, сургууль, тэнхимийн зорилт, хэрэгцээ шаардлага, Багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэсэн байх.
- 2.3.2. Сургалтын заах арга зүйн мэдлэг, үр чадварыг шинэ түвшинд хүргэхэд чиглэсэн сургалт, семинар зохион байгуулах, төсөл хэрэгжүүлэх.
- 2.3.3. Багш нар харилцан суралцах, багш солилцох, гадны дэвшилтэт сайн туршлагыг нэвтрүүлэх, хамтарсан үйл ажиллагаа явуулах боломж, нөөцийг ашиглах.
- 2.3.4. Багшийн гадаад хэлний мэдлэг, хэрэглээг гүнзгийрүүлэн нэмэгдүүлэх, англи хэл дээрх нээлттэй эх сурвалж, материалыг чөлөөтэй хэрэглэдэг, мэргэжлийн хичээлийг англи хэл дээр заах түвшинд эзэмшүүлэх.
- 2.3.5. Мэдээллийн технологийн хөгжил дэвшилд суурилсан нээлттэй, үр дүнтэй, хүртээмжтэй сургалтын олон төрлийн арга, хэлбэрээр /онлайн, холимог гм/ хичээлийг удирдан зохион байгуулах, сургалтын платформуудаас сонгон ашиглах, зайн сургалтын материал боловсруулах, нөөц бүрдүүлэх мэдлэг, үр чадвар эзэмшүүлэх арга зүйн сургалт, зөвлөгөө явуулах.

- 2.3.6. Эрдэм шинжилгээний бага хурал, семинар, вэбинар, хэлэлцүүлэг /форум/ зохион байгуулах, хамтран ажиллах, мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө үзүүлэх үр чадвар эзэмшүүлэх сургалт, зөвлөгөө явуулах.
- 2.3.7. Докторантурт элсэн суралцах, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлүүлэх, судалгааны төсөл хөтөлбөрт оролцох, удирдах, ном, сурах бичиг хэвлүүлэх, нийтлэн бичих үр чадвар эзэмшүүлэх, дэмжих.
- 2.3.8. Багшид хууль эрх зүй, эрүүл мэнд, байгаль, хүмүүнлэгийн ухааны мэдлэг, тогтвортой хөгжлийн /нийгэм-соёл, байгаль орчин, эдийн засаг/ талаар цогц ойлголт олгох, өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөө явуулах.
- 2.3.9. Төлөвлөгөөг чанартай хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг /багш, судлаач/ олж хамтран ажиллах, сургалтын олон арга хэлбэрийг ашигладаг байх.
- 2.4. Багшийг хөгжүүлэх үйл ажиллагаа, сургалт, түүний үр дүн нь "үүнийг сураад хэрхэн яаж хэрэгжүүлэв, хэрэгжүүлсэнээр юу өөрчлөгдөв, юу сайжрав, ямар үр дүн гарав, цаашид үргэлжлүүлэх үү" гэдэгт хариулт авахад оршино.
- 2.5. Багш нь хөтөлбөрийн зорилт, сургуулийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан өөрийгөө хөгжүүлэх хувийн төлөвлөгөө /хавсралт-2/ гарган ажиллах бөгөөд тухайн хичээлийн жилийн Багшийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, хичээлээс сонгон судлахаас гадна зайн сургалт, бусад хэлбэрээр өөр сургалтанд хамрагдаж болно.
- 2.6. Багшийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг Багшийн хөгжил, чадамжийн түвшингээр /хавсралт-3/ тодорхойлох бөгөөд багшийн оролцоо, идэвх чармайлт, санаачлага, гаргасан амжилт нь багшийн албан тушаалын зэрэглэл тогтоох үндсэн үзүүлэлт, багшийн ажлын үр дүн, хяналт-үнэлгээний нэг салшгүй хэсэг байна.
- 2.7. Багшийн хөгжил, чадамжийн түвшинг үнэлэх нэг үзүүлэлт нь сургалтаар эзэмшсэн мэдлэг, үр чадварыг тогтоох сорил, шалгалт байх бөгөөд сургалт удирдсан багшийн үнэлгээ, хөндлөнгийн /БХТөв/ үнэлгээ гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Шалгалт авахдаа тухайн сургалтын чиглэл, хичээлийн онцлогоос хамаарч бичгээр болон амаар, тестээр шалгалт авах, бие даалтын ажил, симуляци, ярилцлага хийх, кейс ажиллуулах, туршилт-судалгаа гэх мэт олон арга, хэлбэрээс сонгож хэрэглэнэ.
- 2.8. Багшийн тухайн хичээлийн жилд ажилласан үр дүнгийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн системд Сургалтын алба, багшийн хувийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан ажлын гүйцэтгэлийг боловсролын салбарын мэдээллийн системд багш өөрөө тус тус илгээнэ.

#### **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТ, ХЯНАЛТ**

- 3.1. Хөтөлбөрийн ерөнхий удирдлага, төлөвлөлтийг сургуулийн захиргаа, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, төлөвлөх, мониторинг хийх, тайлагнах, багшийг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагааг Багшийн хөгжлийн төв хариуцна.
- 3.2. Хөтөлбөрийн санхүүжилт буюу Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг сургуулийн Удирдах зөвлөл батална.
- 3.3. Хөтөлбөр /Багшийн хөгжлийн төв/-ийн санхүүжилтийг "Багшийн хөгжлийн сан" байгуулан бүрдүүлж, түүний төсвөөс зарцуулна. Сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
  - 3.3.1. Сургуулийн төсвийн 3-5 хувь
  - 3.3.2. Захиалгат сургалтын орлогын 30 хувь
  - 3.3.3. Захиалгат судалгааны орлогын 50 хувь
  - 3.3.4. Сэтгэл зүйн зөвлөгөөний төвийн орлогын 40 хувь
  - 3.3.5. Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн орлогын 50 хувь

- 3.4. Ашиг сонирхлын зөрчилгүй этгээд санд хандив, дэмжлэг өгч болно.
- 3.5. Хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.
- 3.6. Сангийн үйл ажиллагааг Эрдмийн зөвлөлийн дарга ахлах бөгөөд бүрэлдэхүүнд нь багш нарын 2 төлөөлөл байна. Сангийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, тайлан тооцоог сургуулийн Нягтлан бодогч хариуцна.
- 3.7. Сангийн үйл ажиллагаа ил тод, орлого, зарлагын мэдээллийг нээлттэй байлгана.
- 3.8. Багшийг хөгжүүлэх зарим сургалтын төлбөрийн 50 хүртэл хувийг багш өөрөө хариуцах ба ямар сургалтын төлбөрийн хэдэн хувийг сургууль хариуцахыг сургалтын эрэлт хэрэгцээ, ач холбогдол, төлбөрийн хэмжээ, багшийн өөрийн санхүүгийн нөөц боломж зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр сургуулийн захиргаа тогтооно.
- 3.9. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр тайлагнаж хэлэлцүүлнэ. Тайланд Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүснэгтийг /хавсралт-4/ хавсаргана.
- 3.10. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хичээлийн жил бүр Багшийн хөгжлийн төлөвлөгөө, төсвийг батлан хэрэгжүүлэх бөгөөд биелэлт, үр дүн нь хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх үндсэн үзүүлэлт болгоно.
- 3.11. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багшийг хөгжүүлэх үйл ажиллагааны тайлан болон сангийн зардлын тайланг сургуулийн захиргаа жил бүр багш нарын хамт олонд танилцуулж, үр өгөөжийг тооцдог байна.



## НССДС-ИЙН "ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ" ХӨТӨЛБӨР (2022-2030)

### Нэг. Нийтлэг үндэслэл

НҮБ-аас баталсан 2030 он хүртэлх Дэлхийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд боловсрол, судалгааны ажил чухал ач холбогдолтой бөгөөд зорилгыг хэрэгжүүлэх арга зам, бодлогын хувилбар, тодорхой шийдлүүдийг боловсруулах, санал болгох, нэвтрүүлэхэд их, дээд сургуулиудын үүрэг, оролцоо нэн чухал юм.

Оюутан залуучууд болон иргэд нийгэмдээ болон байгаль орчиндоо мэдэгдэхүйц эерэг хувь нэмэр оруулах санал санаачилга гаргахад дэмжин хүлээн авч, нэгдсэн ашиг сонирхлын дор их, дээд сургуулиуд хамтран ажиллах, шинэ хэлбэрийн хамтын ажиллагааг бий болгох, өргөжүүлэх нөхцөл, шаардлага бий болж байна. Түүнчлэн их, дээд сургуулид өөрсдийн эрхэм зорилго, стратеги, тэргүүлэх чиглэл, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ эргэн харах, нийгмийн асуудлуудад шинжлэх ухааны үндэстэй, баталгаа нотолгоонд тулгуурласан бодлогын шийдлийг боловсруулах, их, дээд сургуулиуд хөгжлийн стратеги, бодлого, төлөвлөгөөндөө тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмрээ нарийвчлан тодорхойлох хэрэгтэй болжээ.

Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн асуудалд бүх нийтээрээ оролцох, хувь хүн бүрийн үүрэг оролцоо хамгийн чухал болохыг олон түмэнд ойлгуулах, таниулах, энэ талаар тодорхой мэдлэг, боловсрол, чадвар олгох чиглэлээр манай улсын их, дээд сургуулиуд идэвхтэй үйл ажиллагаа явуулснаар улс орныхоо хөгжил дэвшилд болон цаашилбал, дэлхий нийтийн өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэхэд оролцох боломжтой юм. Нөгөө талаар тогтвортой хөгжлийн зорилго, ач холбогдлын тухай гүнзгий мэдлэгтэй төгсөгчдийг их, дээд сургуулиудаас манай нийгэм хүлээж байгаа нь гарцаагүй юм. Иймд их, дээд сургуулиудын сургалтын агуулга, арга зүйг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу өөрчлөх нь чухал байна.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зарчим, санхүүжилт

2.1. НССДС нь дээд боловсролын сургалтын байгууллагын хувьд НҮБ-аас баталсан "Тогтвортой хөгжлийн зорилго-2030", УИХ-аас баталсан "Алсын хараа 2050" хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх шинэ үеийнхнийг бэлтгэх, нийгэм, олон нийтэд тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, түүний мөн чанар, ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү хөтөлбөрийг батлав.

2.2. Хөтөлбөрийг 2022-2030 онд, нээлттэй, тэгш, тасралтгүй, хүртээмжтэй, хувь хүний үүрэг, оролцоо, идэвх чармайлтыг өрнүүлэх, тэдний нөлөөллийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан сургуулийн захиргаа, оюутны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хамт олны нэгдмэл үйл ажиллагааг эрхэмлэн хэрэгжүүлнэ.

2.3. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- Сургуулийн төсөв;
- Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;
- Бусад эх үүсвэр.



## **Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүн, хамрах хүрээ**

3.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ манай сургууль өөрийн нөөц боломжид тулгуурлан “Тогтвортой хөгжлийн 17 зорилго”-оос дараах зорилгуудад илүү ач холбогдол өгч, зорилт дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Зорилт 1: Чанартай боловсрол олгоно. /ТХЗ-4/
- Зорилт 2: Эрүүл мэндийг дэмжинэ. /ТХЗ-3/
- Зорилт 3: Жэндериин эрх тэгш байдлыг хангана. /ТХЗ-5/
- Зорилт 4: Хариуцлагатай хэрэглээг дэмжинэ. /ТХЗ-12/
- Зорилт 5: Ядуурлыг устгахад хувь нэмэр оруулна. /ТХЗ-1/

3.2. Зорилт-1-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжүүлж, чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэн, тасралтгүй хэрэгжүүлнэ.
- Хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх, ирээдүйн ач холбогдлыг ойлгуулах, мэдлэг, чадвар олгох чиглэлийн сэдэв, агуулга бүхий сургалтыг тогтмол явуулна.
- Багшийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг дунд болон үрт хугацаанд хэрэгжүүлнэ.
- Шалгалт, даалгавар, бичгийн ажил, эрдэм шинжилгээний ажил, диссертацийг бусдын ажлаас хуулахаас хамгаалж, судлаачийн ёс зүй, зохиогчийн эрх, плагиаризмын /plagiarism/ талаар мэдлэг, чадвар олгох сургалтыг багш, ажилтан, оюутнуудын дунд жил бүр зохион байгуулна.
- Сургалтын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, дэд бүтэц, сургалтын материал хангалтыг сайжруулж, хөгжлийн бэрхшээл, жэндериин мэдрэмжтэй боловсролын үйлчилгээ үзүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Шударга, зөв хүмүүжил төлөвшилтэй дэлхийн залуу иргэнийг бэлтгэхэд анхаарч сургуулийн хэмжээнд авилгын эсрэг бодлого, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

3.3. Зорилт-2-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Сургуулийн хэмжээнд эрүүл мэнд, биеийн тамир, амьдралын зөв хэв маягийг дэмжих чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- Багш, ажилтан, оюутан, суралцагсадын эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамираар хичээллэх боломж нөхцлийг бүрдүүлэн, тогтмол үйл ажиллагаа зохион байгуулж хэвшүүлнэ.
- Тамхи, согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ нь хувь хүн, гэр бүл, нийгэмд ямар их хор хөнөөлтэйг залуу үед үхуулан таниулах чиглэлээр бодлого, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

3.4. Зорилт-3-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байдлыг хангах, үнэлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Жэндериин эрх тэгш байдлыг хангах, хөхүүлэн дэмжих чиглэлээр бодлого боловсруулж, тогтмол үйл ажиллагаа зохион байгуулж ажиллана.
- Хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан жэндериин эрх тэгш байдлын боловсрол олгоно.

### 3.5. Зорилт-4-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Хувь хүний болон гэр бүлийн санхүүгээ төлөвлөх, үр ашигтай худалдан авалт хийх чиглэлээр оюутан залуучуудад сургалт, сурталчилгаа тогтмол зохион байгуулна.
- Зохистой хэрэглээг ажил, амьдралдаа нэвтрүүлэх, хэвшүүлэх, минималист хэв маягыг эрхэмлэх чиглэлээр оюутан залуучуудад сургалт, сурталчилгаа тогтмол зохион байгуулна.
- Эх дэлхий, байгаль орчиноо хайрлан хамгаалах, хог хаягдыг бууруулах чиглэлээр экологийн боловсрол олгох хичээлийг сургалтын төлөвлөгөөнд оруулж хэрэгжүүлнэ.

### 3.6. Зорилт-5-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Оюутныг дэмжих үйлчилгээний хүрээнд ядуу өрхийн гишүүнийг хөнгөлөлттэй нөхцлөөр суралцуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Амжилттай суралцсан нийгмийн эмзэг бүлэгт хамраах төгсөгч байвал ажлын байраар хангах, ажлын байранд зуучлах ажилд онцгой анхаарч ажиллана.

3.7. Түс хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сургуулийн багш, ажилтан, оюутнууд байгаль орчин /хүрээлэн буй орчин/, үр ашигтэй эдийн засаг, эрүүл аж төрөх талаар мэдлэг, чадвар эзэмшиж, жил бүр 220-250 хүн шууд, тэдний гэр бүл, найз нөхөддөө үзүүлэх нөлөөлөөр нийт 1000 гаруй хүн шууд бусаар хамрагдаж тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэх, 17 зорилгуудыг хэрэгжүүлэхэд манай сургууль бодитой хувь нэмэр оруулна.

### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хяналт үнэлгээ**

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг захирал удирдлагаар хангаж, Сургалтын алба, Оюутны зөвлөл хэрэгжүүлж үр дүнг тайлагнах ба хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг ХЧБА гүйцэтгэнэ.

4.2. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг Захирлын зөвлөлөөр хэлэлцэж захирал батална.

4.3. Сургуулийн алба, нэгж, багш, ажилтан, оюутнууд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, тогтвортой хөгжлийг бүтээх үйлсэд хувь нэмэр оруулна.

4.4. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг мэдээ, тайлан, баримт нотолгоогоор үнэлэх ба хөтөлбөрийн тайлан, ач холбогдлыг жил бүрийн 5-р сард олон нийтэд мэдээллэн сурталчилж байна.



**НССДС-ИЙН "ХАМТ ОЛОН, ОЮУТАН СУРАЛЦАГЧИЙГ  
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, ОЛОН НИЙТ, ХҮМҮҮНЛЭГИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ" ХӨТӨЛБӨР  
(2023-2027)**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн зорилгыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийт, хүмүүнлэгийн үйл ажиллагааг дэмжих, нийгэм, хамт олон, оюутан суралцагчийг соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах, санал болгох нь их, дээд сургуулиудын хувьд онцгой чухал юм.

Оюутан залуучуудыг хөгжүүлэх, соён гэгээрүүлэх, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэх иргэдийг бэлтгэх, нийгэмд туслах, туламдсан асуудлыг шийдвэрлэх нийтийн ашиг сонирхлын дор их, дээд сургуулиуд харилцан туршлага солилцох, хамтран ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

**Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зарчим, санхүүжилт**

2.1. НССДС нь дээд боловсролын сургалтын байгууллагын хувьд нийгмийн хариуцлагаа ухамсарлан УИХ-аас баталсан “Алсын хараа 2050” хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан боловсрол, соён гэгээрэл, хүний хөгжил зэрэгтэй холбоотой зорилтуудыг хэрэгжүүлэх, нийгэм, олон нийтэд хүмүүнлэгийн болон мэргэжлийн чиглэлийн үйлчилгээ үзүүлэх, тэднийг соён гэгээрүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү хөтөлбөрийг батлав.

2.2. Хөтөлбөрийг 2023-2027 онд тасралтгүй, хүртээмжтэй, нээлттэй зарчмыг баримтлан сургуулийн захиргаа, оюутны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хамт олны нэгдмэл үйл ажиллагааг эрхэмлэн хэрэгжүүлнэ.

2.3. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- Сургуулийн төсөв;
- Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;
- Бусад эх үүсвэр.

**Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа,  
хүрэх үр дүн, хамрах хүрээ**

3.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ сургууль өөрийн нөөц боломжид тулгуурлан олон нийтийг соён гэгээрүүлэх, хүмүүнлэгийн чиглэлээр дараах зорилт дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Зорилт 1: Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлнэ.
- Зорилт 2: Олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулна.
- Зорилт 3: Хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

3.2. **Зорилт-1-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- Үндсэн хөтөлбөрийн оюутнуудад сэтгэл зүйн чиглэлээр үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

- Сондгой тоотой сар бүр хүүхэд, насанд хүрэгчид болон гэр бүлд сэтгэл зүйн чиглэлээр үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- Иргэд, олон нийтэд сэтгэл зүйн боловсрол олгох богино сургалтыг хөнгөлөлттэй нөхцлөөр зохион байгуулна.

### 3.3. Зорилт-2-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Сургуулийн вэб сайт, пэйж хуудсаар дамжуулан сэтгэл зүйн боловсрол, танин мэдэхүйн сэдэв, агуулга бүхий мэдээлэл, контент бэлтгэж нийгэм, олон нийтэд тогтмол хүргэнэ.
- Телевиз, радиотай хамтран иргэдэд сэтгэл зүйн чиглэлээр мэдээлэл хүргэж, боловсрол олгоно.
- Оюутнуудад үндэсний соёл, зан заншил, шинжлэх ухааны ололт, амжилт, техник технологийн дэвшил, харилцааны ур чадвар эзэмшүүлэх, тэднийг төлөвшүүлэх зорилгоор албан бус сургалт зохион байгуулах, тэдний үүсгэл санаачлагыг дэмжин ажиллана.

### 3.4. Зорилт-3-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- Улс, нийслэл, дүүргийн хэмжээнд төрийн болон ТББ, олон улсын байгууллага, хөтөлбөр, төслийн газраас хэрэгжүүлж буй хүмүүнлэгийн үйл ажиллагаа, аян, эвентэд хамт олноороо сайн дураараа оролцоно, хамтран ажиллана.
- Сургуулийн хэмжээнд хүмүүнлэгийн аянг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж нийгмийн эмзэг хэсэг, бүлэгт тусламж үзүүлнэ.
- Сургууль дээр “Өгье-Авъя” буланг тогтмол ажиллуулж, бие биедээ туслах ажлыг нийт хамт олон, оюутан суралцагсадын дунд зохион байгуулна.

## **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хяналт үнэлгээ**

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг захирал удирдлагаар хангах ба тэнхим, Оюутны зөвлөл, төлөвлөн хэрэгжүүлж үр дүнг тайлагнах ба хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг ХЧБА гүйцэтгэнэ.

4.2. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг Захирлын зөвлөлөөр хэлэлцэж захирал батална.

4.3. Сургуулийн алба, нэгж, багш, ажилтан, оюутнууд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, тогтвортой хөгжлийг бүтээх үйлсэд хувь нэмэр оруулна.

4.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны мэдээг тухай бүр олон нийтэд хүргэж ажиллана.

4.5. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг мэдээ, тайлан, баримт нотолгоогоор үнэлэх ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, ач холбогдлыг жилд бүрийн 5-р сард олон нийтэд мэдээллэн сурталчилж байна.